

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 65.020.40

| | |
|--|------------------|
| Мод, сөөгний үр тарьсны дараа арчлах. Ерөнхий шаардлага | MNS 6253-3 :2011 |
| Caring of trees and shrubs after the planting. General requirement | |

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2011 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 25 дугаар тогтоолоор батлав.

Энэ стандартыг улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн мөрдөнө.

1 Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь мод үржүүлгийн газар тарьсан үрийн хэвийн өсөлтийг хангаж арчлахад хамаарна.

2 Норматив ишлэл

Энэхүү стандартад дараах баримт бичгийг иш татсан бөгөөд эдгээр стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны материалаас иш татаж хэрэглэнэ.

- MNS 6140 : 2010, Мод, сөөгний тарьц. Техникийн шаардлага,
- ГОСТ 3317: 90, Мод, сөөгний тарьц. Техникийн шаардлага.

3 Нэр томъёо, тодорхойлолт

3.1

Тарьц

Мод үржүүлгийн газарт үр болон мөчрөөр ургуулсан 1-ээс 2 настай модлог ургамал.

4 Техникийн шаардлага

4.1 Тарьсан үрийн арчлалт

Төрөл бүрийн мод, сөөгний үрийг тарьсны дараа соёлолтын өмнөх ба дараах гэсэн 2 чиглэлээр арчлалтыг хийнэ.

4.2 Соёлолтын өмнөх арчилгаа

Үрийн соёо ил гарахаас өмнөх арчилгаанд тарьсан үрээ нягтруулж булдах, хучих, хөрсний өнгөн үеийг үр булсан гүнд хүргэхгүйгээр зөөлөн сийрүүлэх, хог ургамлыг цэвэрлэх, услах, тарьсан үрээ салхинд хийсэхээс хамгаалах зэрэг арчилгаанууд орно.

4.2.1 Мод, сөөгний үрийг тарьсны дараа арзгар булаар булдана. Хэрвээ гөлгөр булаар булдсан бол үр тарьсан гүнд тохируулан хөнгөн сийрүүлнэ.

MNS 6253-3 : 2011

4.2.2 Хөрсний чийгийн алдагдлыг багасгах, хөрсний өнгөн үе өрөмтөж нягтрах, нарны хэт халалтаас хамгаалах, шөнийн цагт дулаан хадгалах зорилгоор үртэс сүрэл ялзмагаар үр тарьсны дараа 1-ээс 1,5 см хүртэл зузаан хучина. Үр жигд соёолж эхэлмэгц хучлагыг хагаслан авч, эхний 2 навч гарахад хучлагыг бүрэн авна.

4.2.3 Хөрсөнд үр булсан хэсэгт чийгтэй байхаар зөөлөн усална.


4.3 Соёололтын дараах арчилгаа

Тарьсан үрийн соёо ил гарсны дараах арчилгаанд

- сүүдэрлэх,
- хөрсийг сийрүүлэх,
- услах, бордох,
- хог ургамлыг цэвэрлэх,
- хортон шавж, өвчинтэй тэмцэх аргууд багтана.

4.3.1 Сүүдэрлэлт. Шилмүүст мод, хус, улиасны шинэхэн гарсан соёог нарны шууд тусгал, тарьцыг цочир хүйтнээс хамгаалах, хөрсний чийгийн ууршилтыг багасгахаар сүүдэрлэж өгнө. Сүүдрэвчийг модны нарийн мөчир, зэгс, сүрэл, модон хаалтаар хийнэ.

Сүүдрэвчийг тарьцан дээр нар тусах талаас 45°-ийн налуу, босоо ба хэвтүүлэн тавьж, намар 8 дугаар сарын эхээр авна.



1-р зураг. Тарьц хамгаалах сүүдрэвч
1 – босоо байрлуулах, 2- налуу байрлуулах, 3- хэвтээ байрлуулах

4.3.2 Хөрс сийрүүлэлт. Эгнээ хооронд хөрсийг сийрүүлэх, хог ургамлыг устгах ажлыг шилмүүст модонд эхний жилд 5-аас доошгүй, 2 дахь жилд 4-оос доошгүй, 3 дахь жилд 3-аас доошгүй, навчит модонд эхний жилд 4-өөс доошгүй, дараагийн жилд 3-аас доошгүй удаа хийнэ. Бороо орсны дараа хөрсийг өрөмтөхөөс хамгаалан сийрүүлнэ.

4.3.3 Усалгаа. Үр тарьсны дараа соёололт жигдэрч ил гарах хүртэл хөрсний 5-аас 10 см-ын гүнд, үр соёолж үндэсний систем бүрэлдэх үед хөрсний 15-аас 20 см гүнд, тарьцны өсөлт нэмэгдэж хэлбэржих үед хөрсний 30 см-ийн гүнд усалгааг эхний сард 1 дэх долоо хоногт өдөр бүр, 2 дахь долоо хоногт 4 –оос доошгүй, 3 дахь долоо хоногт 2-оос доошгүй удаа хийнэ. Хоёр дахь сараас эхлэн долоо хоногт 1 – ээс доошгүй удаа усална. Намар цэнэг усалгааг хийнэ.

4.3.4 Бордох. Нэмэлт бордоог 1 га-д фосфорын бордоо 60 кг, азотын бордоо 50 кг, калийн бордоо 10 кг-ыг нэмж хийнэ.

4.3.5 Үр соёолж жигдрэх үед соёололт шигүү байвал 1 уртааш метр мөрөнд шилмүүст модны тарьц 100-аас 150 ш; навчит модных 40-өөс 50 ш байхаар бодож гэмтсэн, өвчилсөн, хөгжилт султай тарьцыг авч сийрүүлнэ.

4.3.6 Цочир хүйтнээс хамгаалахын тулд хуурай, нойтон аргал, бууц, модны гишүү, мөчир, сүрлийг урьдчилан бэлтгэж хамгаалах талбайгаа тойруулан 3-аас 5 метр зайтай овоолно. Цочир хүйтэн болоход овоолсон зүйлээс нэгийг алгасан асааж, хүйтрэлт хүчтэй болоход үлдсэнийг асаана.

4.3.6 Тарьсан үрийг мөөгөнцөр өвчнөөс хамгаалж 2 удаа 0,25 %-ийн марганц калийн (2,5 г-ыг 1 л усанд уусган) уусмалаар 2-оос багагүй шүршинэ.

ТӨГСӨВ.